

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 19 (ТОЙМ)

Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 14 цаг 30 минутанд эхэлж, 16 цаг 30 минут хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 00 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд аэронавигацын үйлчилгээний газрын даргын албан тушаалд Балдандоржийн Алтанцомыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад санал болгох тухай Монгол Улсын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
2	Нийслэлийн дүүргүүд, түүний харьяа зарим байгууллагын төрийн албан хаагчийн хэрэгцээ, хангалтын үйл ажиллагааг шалган зааварласан дүнгийн мөрөөр хийсэн ажлын тайлан	Ерөнхийд нь хангагдсан гэж үзэв. Нэг зүйлээ гүйцээж энэ 11 сард эргэж тайлагнах. Цаашид хийх үзлэгийнхээ хүрээнд ёс зүйн асуудлыг түлхүү оруулж үзэх нь зүйтэй. Мөн хүний нөөцтэй холбоотой ямар зөрчил гаргав, хүнийхээ асуудлыг яаж шийдэж байна вэ гэдгийг гол үзүүлэлт болгож дүгнэх нь зүйтэй гэж үзэв.
3	Засгийн газрын зарим агентлагийн сул орон тоог нөхөхөөр 2010 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүн, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	1.2010 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан Төрийн жинхэнэ албаны МШ-д тэнцсэн нийт 31 иргэн (үүнээс Эрүүл мэндийн газарт 26, Жижиг, дунд үйлдвэрийн газарт 5)-ийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэснийг нэгдүгээр хавсралтаар батлах,  2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 4 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 2 дугаар хавсралтаар батлах,  3.Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр

		<p>бүхий 4 иргэнийг тухайн албан тушаалд томилохыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Содномпилд үүрэг болгох,</p> <p>4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТАЗ-ийн гишүүн, ТА-ны Мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгасан тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Бусад асуудалд: Зарим хүмүүсийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шалгаруулан шагнах тухай	Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан Намсрайн Тунгалаг, Батхүүгийн Цэцэгмаа нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шалгаруулан шагнах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын шийдвэр гаргахаар тогтов.